

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗАР**

**ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2020 ОНЫ
1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

2020.03.30

Өлгий сум

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын болон захиргааны үйл ажиллагааны баримт бичгийн зүйл, заалтын хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж, хангаж буй талаар.

1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/01 дүгээр тушаалаар баталсан Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2020 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэж, Цагдаагийн газрын 2020 оны гүйцэтгэлийн 56 заалт бүхий төлөвлөгөөг Цагдаагийн газрын даргын 2020 оны А/01 дүгээр тушаалаар, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх 19 заалт бүхий ажлын төлөвлөгөөг 2020 оны 01 дүгээр сарын сарын 02-ны өдөр тус тус баталж, хэрэгжилтийг 30.1 хувьтай хангав.

2. Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” А/65 дугаар тушаалаар Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгүүдийг баталсантай холбоотой Цагдаагийн газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/26 дугаар тушаалаар “Цагдаагийн газраас 2020 онд хяналтанд авч, хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт”-ыг баталж, тогтоосон хугацаанд тайлагнаж, холбогдох алба, нэгжид хүргүүлэхийг тасгийн дарга болон урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн нарт хариуцуулсан.

Энэ онд нийт 96 баримт бичгийг хяналтанд авч хэрэгжилтийг тайлагнах ёстой ба 2020 оны 1 дүгээр улиралд тайлагнахаар тусгагдсан холбогдох 8 төрлийн баримт бичгийн хэрэгжилтийг ханган тогтоосон хугацаанд холбогдох алба, нэгжүүдэд хүргүүлсэн.

3. Дээд шатны байгууллага, удирдах албан тушаалтнаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийг алба хаагч нэг бүрт хүргэх, ялангуяа сумдад үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад тухай бүрт нь хүргэн судлуулах, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, үүрэг, ажлын чиглэлийн нэгдсэн бүртгэл хөтөлж баримт үйлдэх, тайлагнах үүрэг бүхий орон тооны бус багийг Цагдаагийн газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/67 дугаар тушаалаар байгуулж, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар Цагдаагийн ерөнхий газрын даргын 1, Тэргүүн дэд даргын 9, Дэд даргын 15, нийт 25 төрлийн даалгавар, үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж, дээд шатны байгууллага, удирдах албан тушаалтнаас ирүүлсэн 68 төрлийн үүрэг, ажлын чиглэл, мэдээллийг алба хаагч нэг бүрт хүргэж, хэрэгжилтийг хангуулж, хэрэгжилтийг тогтоосон хугацаанд хүргэх ажлыг зохион байгуулсны үр дүнд алба хаагч бүрт жигд хүртээмжтэй хүрч, хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн.

Дээд шатны байгууллага, удирдлагаас ирүүлсэн албан даалгавар, үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж, мэдээллийг алба хаагчдад мэдээлсэн, түүний дагуу

хэрэгжүүлсэн ажил, үр дүнгийн талаар тусгайлан бүртгэл гарган ажлын баримт үйлдсэн.

Мөн холбогдох хууль тогтоомж, журам, дээд шатны байгууллага, удирдах албан тушаалтнаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийг алба хаагч нэг бүрт хүргэн судлуулах, хэрэгжилтийг хангуулах, мэдээ мэдээллээр тасралтгүй хангах, хэрэгжилтэнд тавих хяналтыг дээшлүүлэх зорилгоор Цагдаагийн газрын тасгийн дарга нараас өглөөний нэгдсэн цугларалтын үед алба хаагчдад танилцуулах мэдээллийн хуваарийг 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдөр баталж, хэрэгжилтийг хангуулав.

4. Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн сүлжээ болон бусад байгууллагаас ирүүлсэн 1035 албан бичгийг хүлээн авч бүртгэж, 1258 албан бичиг, мэдээг тогтоосон хугацаанд холбогдох цагдаагийн байгууллагуудад хүргүүлэв.

5. Хууль зүй, дотоод хэргийн сайдтай аймгийн Засаг даргын 2020 онд хамтран ажиллахаар байгуулсан гэрээнд тусгагдсан 11 төрлийн ажил, арга хэмжээний хэрэгжилтийг 35 хувьтай, аймгийн Засаг дарга Цагдаагийн газрын даргатай байгуулсан 2020 оны гүйцэтгэлийн гэрээнд тусгагдсан 19 төрлийн ажил, арга хэмжээний хэрэгжилтийг 36 хувьтай тус тус хангасан.

6. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 11 төрлийн ажил, арга хэмжээг хэрэгжүүлсэн.

7. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд дэвшүүлсэн “Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, харилцааны соёлыг дээшлүүлнэ” зорилтын шалгуур үзүүлэлтийн 5 дахь заалтын “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, харилцааны соёлын талаар иргэд, олон нийтээс санал асуулга авч, түүний мөрөөр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг төлөвлөн, зохион байгуулж, үр дүнг тооцсон байх” хэрэгжилтийг хангах зорилгоор тус аймгийн нийт 13 сум, 1 тосгоны 386 хүнээс 9 асуултын хүрээнд боловсруулсан санал асуулгыг 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд авч, дүнг нэгтгэж Цагдаагийн газрын даргын 2020 оны 4 дэх хуралдаанаар хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгч, гаргасан 9 төрлийн саналын хэрэгжилтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.

Цагдаагийн газрын үндсэн үйл ажиллагаа болох гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажилд үнэлгээ өгнө үү гэсэн асуултанд 189 буюу 54.3 хувь нь сайн, 108 буюу 31.1 хувь нь дунд, 11 буюу 3.2 хувь нь муу, 33 буюу 9.4 хувь нь мэдэхгүй гэж тус тус хариулсан нь Цагдаагийн газрын үйл ажиллагаа иргэд, олон нийтэд жигд хүртээмжтэй хүрч байгааг харуулж байна.

8. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Ахмадын байгууллага, ахмад настны талаар авах арга хэмжээ /код 947/ журам”, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2018 оны “Ахмад настнуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” А/223 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах зорилгоор “Сар шинэ”, “Наурыз”-ын баярыг угтан тус Цагдаагийн газрын 70 ахмад ажилтанд хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардуулж, “Ахмадын сан”-д 300.000 төгрөг хандивлав.

Сар бүрийн сүүлийн 7 хоногийг цагдаагийн газрын ахмад ажилтнуудтай ажиллах өдөр болгож, ахмадын хороо, зөвлөлтэй хамтран тодорхой ажил зохион байгуулах, ахмад ажилтнуудыг хариуцан ахуй амьдралтай нь танилцаж, санал хүсэлтийг сонсож, хамтран ажиллах алба хаагчдыг цагдаагийн газрын 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/22 дугаар тушаалаар хариуцуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

1.2. Байгууллагын даргын зөвлөлийн хуралдаан тайлангийн хугацаанд хуралдсан байдал, шийдвэрлэсэн асуудлын талаар.

1. Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөл нийт 8 удаа хуралдаж 64 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн.

2. Стандартчилал Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлүүдийг байрлуулахад тавих стандарт” болон Архивын Ерөнхий газрын даргын 2009 оны 69 дүгээр тушаалаар шинэчлэгдэн батлагдсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн заавар”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын тушаал гаргах /код 136/ журам”-ын дагуу Цагдаагийн газрын даргын хүний нөөц, алба хаагчдад холбоотой гаргасан А тушаал 34, цагдаагийн газрын үйл ажиллагаатай холбоотой гаргасан Б тушаал 19, нийт 63 тушаалыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу боловсруулан гаргасан.

1.3. Хүний нөөцийн бодлогын талаар:

1. Төрийн албаны тухай хууль, ЦЕГ-ын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолт боловсруулах /код 106/ журам”-ын дагуу тухайн албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг шинээр баталгаажуулсан албан тушаалын тодорхойлолтуудыг алба хаагч бүртэй танилцуулан хэрэгжилтийг хангуулсан.

2. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/179 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагад ажиллах иргэнд тавигдах тусгай шаардлага, шалгуур үзүүлэлт тооцох журам”, Цагдаагийн ерөнхий газраас Хүний нөөцийн хэлтсээс 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 56/277 дугаар албан бичгээр ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийн дагуу цагдаагийн байгууллагад анх орох иргэний сонгон шалгаруулалтыг зохион байгуулан ажилласан.

3. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Албан тушаал дэвшүүлэх /код-909/ журам”-д заасан болзол шалгуурыг хангасан 2 алба хаагчийг тасгийн даргаар, 4 алба хаагчийг ахлах албан тушаалд, 2 алба хаагчийг ахлагч бүрэлдэхүүнээс офицер бүрэлдэхүүнд шилжүүлж, тус тус албан тушаал дэвшүүлэн томилуулсан.

4. Цагдаагийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэдээс авсан шалгалтанд тэнцэж, цагдаагийн мэргэжлийн мэдлэг олгох дамжаанд суралцаж төгссөн 1 иргэнийг Цагдаагийн газрын даргын 2020 оны Б/13 тушаалаар томилж, цол олгосон.

5. Цагдаагийн албаны тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 74 дүгээр тогтоолын дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар аймгийн төвөөс бусад суманд 5-аас дээш жил ажилласан 1 алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшлыг олгосон.

6. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан “Алба хаагчид албаны үнэмлэх, энгэрийн тэмдэг олгох, хураан авах журам /код 916/”-д заасны дагуу 4 алба хаагчын албаны үнэмлэх, энгэрийн тэмдгийг шинээр, 4 алба хаагчийг шинэчлэн олгуулсан.

1.4. Алба хаагчдын дунд зохион байгуулсан албаны сургалт, түүний үр дүнгийн талаар.

1. Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны “Албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай” А/07 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор Цагдаагийн газрын даргын 2020 оны А/16 дугаар тушаалаар “Албаны сургалт явуулах баг байгуулж, сургалтын

төлөвлөгөө"-г баталсан бөгөөд нийт 65 төрлийн сэдвийн хүрээнд 115 цагийн сургалтыг 15 сургагч багш зохион байгуулахаар төлөвлөсөн.

Зохион байгуулсан нийт 20 удаагийн, 41 цагийн сургалтанд давхардсан тоогоор 2311 алба хаагчийг хамруулсан бөгөөд Цагдаагийн газрын төсвөөс 450.000 төгрөгийг зарцуулсан ба сургалтын мэдээллийг "Сургалтын мэдээллийн нэгдсэн бүртгэлийн сан /E surgalt/"-д бүрэн шивж мэдээллийн бааз үүсгэсэн.

Үүнээс мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалтыг 7 удаа 11 цаг, алба хаагчийг хөгжүүлэх сургалтыг 6 удаа 7 цаг, дадлагажуулах сургалтыг 1 удаа 4 цаг, бие бялдарын бэлтгэлжилтийн сургалтыг 1 удаа 4 цаг, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 5 удаа 15 цагийн сургалтыг тус тус зохион байгуулсан.

- Сургалтанд хамрагдсан алба хаагчийн тоог өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 498 алба хаагч буюу 21.5 хувиар нэмэгдсэн байна.

2. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд дэвшүүлсэн зорилт түүний шалгуур үзүүлэлтийг алба хаагч бүр өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөх, дадал зуршил болгон хэвшүүлэх зорилгоор Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнд 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр сургалт зохион байгуулж, зорилтыг нэг загвараар хэвлэн алба хаагч нарт тараан хэрэгжилтийг хангуулсан.

3. Хэсгийн төлөөлөгч нарын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор "Хэсгийн төлөөлөгч нарын нэгдсэн сургалт"-ыг 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр 12 сэдвийн хүрээнд зохион байгуулан сургалтанд давхардсан тоогоор 130 гаруй алба хаагч хамрагдсан ба хэсгийн төлөөлөгч нарын мэдлэг, ур чадвар дээшлэхэд нөлөөлөв.

4. Аймгийн Прокурорын газартай хамтран 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр, 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр, 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдөр, нийт 3 удаа сургалт зохион байгуулсан бөгөөд эрүүгийн хууль, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, зөрчлийн тухай хууль болон зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудыг хэрэгжүүлэх явцад гарч буй хүндрэл бэрхшээл, түүнийг арилгах арга хэмжээний талаар хэлэлцэж, зөрчил дутагдлыг арилгуулах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.

5. Албаны сургалтыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу зөвхөн онолын мэдлэг олгох бус практик ур, чадварыг онолтой хослуулах арга хэлбэрээр хэрэгжүүлж ажилласны үр дүнд сургалтын чанар, хүртээмж нь нэмэгдсэн, алба хаагчдын хууль хэрэглэх ур чадвар, харилцааны соёл, албаны бэлэн байдал, *цэрэжилч, жагсаалч байдал* дээшилж, алба хаагчдын зүгээс цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм, ёс зүйн дүрмийг нэг мөр ойлгож, мөрдөх хандлагад эерэг өөрчлөлтүүд гарч байна.

1.5. Алба хаагчдын нийгмийн асуудал, үүрэг гүйцэтгэх нөхцөл, боломжийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаар.

1. Алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлэх 16 төрлийн ажил, арга хэмжээний төлөвлөгөөг 2020 оны 01 дүгээр сарын 17-өдөр баталж, хэрэгжилтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.

2. Цагдаагийн газрын дундын сангийн журмын дагуу нийт 11 алба хаагчдад 830.000 төгрөгний мөнгөн хэлбэрийн тусламж, дэмжлэг үзүүлэв.

3. Цагдаагийн газрын тасаг, хэсгийн дарга нар давхардсан тоогоор 20 гаруй алба хаагчтай ганцаарчлан уулзаж, санаа бодлыг нь сонсож, 50 гаруй алба хаагчийн ахуй амьдралтай биечлэн танилцаж, зарим санал хүсэлтийг холбогдох дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх, түүнчлэн албандаа хүндэтгэлтэй хандах талаар нөхцөл байдлыг бодитой тайлбарлаж ойлгуулах талаар яриа таниулга хийх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.

4. Хэсгийн төлөөлөгч нарын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор сум хариуцсан мөрдөгч нарыг цагдаагийн газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/25 дугаар тушаалаар тасгийн дарга нарт хариуцуулан тодорхой ажил, арга хэмжээг хэрэгжүүлээд байна.

5. Цагдаагийн газрын үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг оновчтой, аргачлал, шалгуур үзүүлэлтийн дагуу тодорхойлж, үнэлгээ өгөх, урьдчилан сэргийлэх санал, зөвлөмж боловсруулан биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий эрсдэлийг удирдах орон тооны бус багийг Цагдаагийн газрын даргын 2018 оны А/65 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд баг Цагдаагийн газрын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг 5 чиглэлээр тодорхойлж, 2020 онд хариу арга хэмжээ авах 23 заалт бүхий ажлын төлөвлөгөөг 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр баталж, хэрэгжилтийг хангуулсан.

Эрсдэл болон учирч болзошгүй, эсхүл учирч байсан хор уршигтай үр дагаврыг зөв тодорхойлж, урьдчилан сэргийлэх буюу бууруулах, хариу арга хэмжээ авах зорилгоор Цагдаагийн газрын тасаг, хэсгийн дарга, дотоодын цэргийн тусгай салааны захирагч, ахлах нягтлан бодогч нарт 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр 33 заалт бүхий 7 дугаартай үүрэг, ажлын чиглэл хүргүүлэн хэрэгжилтийг хангуулав.

6. Цагдаагийн газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/29 дүгээр тушаалаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөлийг, Цагдаагийн газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/30 дугаар тушаалаар үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх, дүгнэлт гаргуулах үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг тус тус шинэчлэн байгуулж, Цагдаагийн газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 02-ний өдрийн А/27 дүгээр тушаалаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны бус ажилтангаар Эрүүлжүүлэх, саатуулах байрны эмчийг томилон ажиллуулж байна.

. Шинэ коронавирусын /covid-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 01 дугаартай зөвлөмж, Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргаас 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдөр баталсан “Шинэ төрлийн коронавирусын тархалтыг хязгаарлах хамгаалалтын үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын сэтгэл зүйг сэргээхэд чиглэсэн ажил, арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

7. Тайлангийн хугацаанд “Эрүүл-цагдаа” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, алба хаагч, ажилтны эрүүл мэндийг дэмжих, эрүүл зөв аж төрөх ёс, зан үйлийг хэвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл чийрэг бие бялдар, сэтгэл зүйг бэлтгэх ажлын хүрээнд 3 удаа сургалт зохион байгуулж, алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалав.

- Эрүүл мэндийн яамнаас гаргасан зөвлөмжийн дагуу Зоонозын өвчин судлалын төвийн мэргэжлийн баг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар баталсан “Хамгаалах хувцас өмсөх дараалал”, “Хамгаалах хувцас тайлах дараалал”-ын заавар, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2020 оны А/15 дугаар тушаалаар баталсан “Коронавируст /Ковид-19/ халдварын үед халдваргүйжүүлэлт хийх түр заавар”-ын талаар сургалт зохион байгуулж, Цагдаагийн газрын төв байр, Эрүүлжүүлэх, саатуулах байранд Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/15 дугаар тушаалаар баталсан “Коронавируст /Ковид-19/ халдварын үед халдваргүйжүүлэлт хийх түр заавар”-ын дагуу бүрэн халдваргүйжүүлэлт хийв.

8. Албаны тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах зорилгоор цагдаа-жолооч болон албаны тээврийн хэрэгсэл хариуцаж байгаа алба хаагчдаас 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр 4 заалт, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа үйлчлэгч, сантехникийн слесарь, мужаан зэрэг энгийн 4 ажилчдаас 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 2 дугаартай 18 заалт бүхий хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар баталгааг авч хэрэгжилтийг тус тус хангуулсан.

9. Хэсгийн төлөөлөгч, хэсгийн цагдаа нарын ажиллах амьдрах нөхцлийг сайжруулах ажилд сум орон нутгийн удирдлагын дэмжлэг, туслалцаа авах зорилгоор Цагдаагийн газрын дарга, сумын Засаг дарга, хэсгийн төлөөлөгч нарын хамтарсан “Гурвалсан гэрээ”-г 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдөр байгуулан аймгийн Засаг даргаар баталгаажуулан биелэлтийг нь тооцов.

Өнөөдрийн байдлаар Улаанхус сумын удирдлагууд орон нутгийн хөрөнгөөр Цагдаагийн хэсэгт “Rav-4” маркийн автомашин олгосон.

10. Тайлангийн хугацаанд Эрүүгийн хуулийн нийтийн албаны ашиг сонирхолын эсрэг 2 гэмт хэрэгт 2 алба хаагч, Зөрчлийн тухай хуулийн хууль ёсны шаардлагыг зориуд үл биелүүлсэн 15 зөрчилд 16 алба хаагч, үүнээс гэмт хэрэгт 2 ахлагч, зөрчилд 3 офицер, 16 ахлагч тус тус өртөж хохирсон бөгөөд гэмт хэрэгт өртөж хохирсон алба хаагчийн тоог өнгөрсөн жилтэй харьцуулахад мөн үеийн түвшинд, зөрчилд өртөж хохирсон алба хаагчийн тоо 1 алба хаагч буюу 0.9 хувиар буурсан.

Гэмт хэрэг үйлдсэн 1 хүнд шүүхээс ял оногдуулсан бөгөөд 1 хүнд холбогдох хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Мөн Зөрчлийн тухай хуулийн хууль ёсны шаардлагыг зориуд үл биелүүлсэн зөрчил үйлдсэн 14 хүнд торгох шийтгэл оногдуулсан байна.

1.6. Нутаг дэвсгэрийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргаар уламжлан шийдвэрлүүлсэн ажил, арга хэмжээ, төсөв хөрөнгө, зарцуулалт, үр дүнгийн талаар.

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 72 дугаар тогтоолоор цагдаагийн газарт явуулын пост худалдан авахад шаардагдах 15.000.000 төгрөг, хамгаалалтын хайс хашаа хийлгэхэд шаардагдах 10.000.000 төгрөг нийт 25.000.000 төгрөгний санхүүжилтийг шийдвэрлэсэн бөгөөд холбогдох тооцоо, судалгааг аймгийн Засаг даргын тамгын газарт хүгүүлсэн.

2. Долоо хоног бүрийн “Баасан” гарагт зохион байгуулагддаг аймгийн удирдах албан тушаалтны шуурхай зөвлөгөөнд нийт удаа оролцож, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хамтын ажиллагааны талаар нийт 12 удаа тодорхой мэдээ, мэдээлэл өгч, шуурхай зөвлөгөөнд оролцсон нийт 40 гаруй төрийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан.

1.7. Цагдаагийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой бусад төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт хамрагдаж байгаа болон бие даан хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, хугацаа, үр дүнгийн талаар.

1. Цагдаагийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой бусад төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт хамрагдаж байгаа болон бие даан хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр байхгүй.

1.8. Тайлангийн хугацаанд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ.

1. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг мэдүүлэх үүрэг бүхий 67 албан тушаалтанд ХАСХОМ-ын талаар 1 удаа сургалт зохион байгуулж, 2019 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2020 оны 02

дугаар сарын 18-ны өдрийн 29/748 дугаар албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлсэн.

Шинээр томилогдсон 1, шилжин ирсэн 3, албан тушаал дэвгсэн 6, нийт 10 алба хаагчдын материалыг Цагдаагийн ерөнхий газарт тухай бүрт нь тус тус хүргүүлж, алба хаагчийн тушаал, шийдвэрийг мэдээллийн цахим бүрдүүлэлтийн санд бүртгэсэн.

2. Авлигын эсрэг хууль, хөтөлбөрийг сурталчлах чиглэлээр иргэдийг хүлээж авах танхимд тусгайлан булан, самбар гарган үйл ажиллагаанд ашиглаж байна.

- Цагдаагийн газрын төв байрны урьд 2.32*3.0 метрийн хэмжээтэй 30.000.000 төгрөгний өртөгтэй “LED” дэлгэцийг байрлуулж, түүгээр дамжуулан авлигын хор уршгийн талаарх мэдээ, мэдээлэл, санамж, зөвлөмжийг түгээж байна.

3. Авлигатай тэмцэх газраас бүтээсэн авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг, хүнд сурталтай үйлчилгээ, албан тушаалтны ёс зүй, зүй бус шаардлагын талаарх мэдээллийг авах 110 тусгай утасны сурталчилгааны шторкийг Авлигатай тэмцэх газрын цахим хуудснаас татан авч, цагдаагийн газрын албан ёсны цахим хуудас /bayan-ulgii.police.gov.mn/, “Баян-Өлгий Цагдаагийн газар” фейсбүүк хуудас, “LED” дэлгэцээр дамжуулан сурталчлах ажлыг тасралтгүй зохион байгуулсан.

1.9. Алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар.

1. Цагдаагийн газрын удирдлагад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 8 алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 7 өргөдөл, гомдол ирүүлсэн бөгөөд бүртгэлд оруулан дугаар олгож, албаны шалгалт явуулж, хуулийн хугацаанд өргөдөл, гомдол гаргагчид хариуг нь шуурхай хүргүүлснээр цагдаагийн байгууллага, иргэдийн итгэлцэл сайжрахад нөлөө үзүүлсэн гэж дүгнээд байна.

Өөрөөр хэлбэл Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар иргэдийн дунд эерэг ойлголт бий болсон.

Өргөдөл, гомдолд 8 алба хаагчийг холбогдуулан шалгасны 3 буюу 37.5 хувийг офицер, 5 буюу 62.5 хувийг ахлагч бүрэлдэхүүн эзэлж байгаа бөгөөд өргөдөл, гомдлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мөн үеийн түвшинд байна.

Төрлөөр нь авч үзвэл: 3 буюу 42.8 хувийг хууль ёс, хүний эрх чөлөөг зөрчсөн, 2 буюу 25 хувийг бусдыг чирэгдүүлж танил тал харсан, 1 буюу 14.2 хувийг хээл хахууль шан харамж авсан, 1 буюу 14.2 хувийг цагдаагийн алба хаагчийн харилцааны соёл, ёс зүй зөрчсөн гэх зөрчлүүд тус тус эзэлж байна.

Өргөдөл, гомдлыг бүртгэж албаны шалгалт явуулахад бүх алба хаагчдын сахилга, ёс зүйн зөрчил гаргасан үйлдэл нь тогтоогдоогүй.

Монгол Улсын Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв” 11-11-д тус цагдаагийн газрын үйл ажиллагаа, алба хаагчдад холбоотой иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ямар нэгэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, бүртгэгдээгүй болно.

Харин Цагдаагийн ерөнхий газрын алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүлээн авах 126 дугаар утсанд цагдаагийн алба хаагч хэл амаарх доромжилсон гэх 1 гомдол мэдээлэл бүртгэгдсэн бөгөөд албаны шалгалт явуулахад тухайн алба хаагч сахилга, ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдоогүй болно.

2. Цагдаагийн газрын удирдлагад хандаж иргэд, алба хаагчдаас 24 өргөдөл, гомдол, мэдээлэл ирүүлсэн бөгөөд “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн Б/99 дүгээр тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэх /код 121/ журам”-ын дагуу хүлээн авч бүртгэн, хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу хүргүүлсэн.

Төрлөөр нь авч үзвэл: 18 буюу 75 хувийг ажилд орох, суралцахыг хүссэн, 2 буюу 8.3 хувийг ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 1 буюу 4.1 хувийг тэтгэвэр тэтгэмж, орон сууц хүсэн, 3 буюу 12.5 хувийг бусад төрлийн өргөдөл, гомдол эзэлж байна.

1.10. Алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан ажил арга хэмжээний талаар.

1. Алба хаагч, ажилтны сахилга, ёс зүйн зөрчил болон гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон, холбогдон шалгагдсан шалтгаан нөхцөлийг 2019 оны байдлаар судалж, урьдчилан сэргийлэх 17 төрлийн ажлыг цагдаагийн газрын Сахилга, ёс зүйн хорооноос төлөвлөн 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр баталж хэрэгжилтийг хангуулсан.

Алба хаагчдын идэвх санаачилгатай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, тэдний хөдөлмөрийг оновчтой зохион байгуулах, сахилга, дэг журмыг бэхжүүлэх, цагдаагийн газрын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Цагдаагийн газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар цагдаагийн газрын дотоод журмыг шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

2. Цагдаагийн газрын даргын 2020 оны А/12 дугаар тушаалаар алба хаагчдын сахилга, ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх, сахилга, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх, бууруулах зорилгоор “Сахилга, ёс зүйн зөрчилгүй хамт олон” аяныг зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд удирдамжийн дагуу 9 төрлийн шалгуур үзүүлэлтээр 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдөр дүгнэх юм.

3. Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсээс алба хаагч, ажилтны сахилга, ёс зүй, харуцлагыг дээшлүүлэх, бууруулах, сахилга, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулах зорилгоор хэрэгжүүлж байгаа “Өнгө нэмцгээе-2020” нөлөөллийн аяныг хуваарийн дагуу Цагдаагийн газрын тасаг, хэсгээс хариуцан зохион байгуулан ажиллаж байна.

Дээрх арга хэмжээний үр дүнд цагдаагийн газрын алба хаагчдаас 2019 оны эхний 3 сарын байдлаар 5 алба хаагч сахилга, ёс зүйн зөрчил гаргасан бол энэ жилийн эхний 3 сарын байдлаар сахилга, ёс зүйн зөрчил гаргасан алба хаагч бүртгэгдээгүй болно.

4. Алба хаагчдын 2020 оны эхний 3 сарын сахилга, хариуцлагын байдалд дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлаа тодорхойлох зорилгоор Цагдаагийн газрын 2020 оны 01 дүгээр улирлын “Сахилга хариуцлагын зөвлөгөөн”-ийг цагдаагийн тасаг, хэсгээс дотооддоо зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 120 гаруй алба хаагч хамрагдав.

Сахилгын зөрчлийн шалтгаан нөхцөлийг судалж, дүн шинжилгээ хийж үзэхэд хувь хүний буруутай үйл ажиллагаа, ёс зүй хангалттай төлөвшөөгүй зэрэг гол шалтгаан нөхцөл тогтоогдоод байна.

5. Цагдаагийн газрын Сахилга, ёс зүйн хорооноос алба хаагчдаас гаргасан сахилга, ёс зүйн зөрчил, хариуцлагын байдалд дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоож, арилгуулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар тасаг, хэсгийн дарга, дотоодын цэргийн тусгай салааны захирагч нарт 2020 оны 01 дүгээр сарын 13-ний өдрийн 17 заалт бүхий 01 дугаартай хэрэгжих боломжтой үүрэг, ажлын чиглэл хүргүүлэн хэрэгжилтийг хангуулсан.

6. Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргаас 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 3/73 дугаар албан бичгээр “Итгэлцлийн гэрээ” байгуулахтай холбоотой ирүүлсэн үүргийн дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/57 дугаар тушаалаар баталсан “Итгэлцлийн гэрээ”-ний загварын дагуу Цагдаагийн газрын нийт 152 алба хаагч, ажилтан бүртэй 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр байгуулан гэрээний хугацааг 1 жилийн хугацаатай сунгаж хэрэгжилтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авсан.

Итгэлцлийн гэрээ зөрчсөн алба хаагч бүртгэгдээгүй.

7. Сахилга, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр 4 удаагийн үүрэг, ажлын чиглэл, мэдээллийг өгч үр дүн, биелэлтийг улирал, хагас жилээр тооцож, өргөсөн тангарагтаа үнэнч байх, цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрмийн хэрэгжилт, алба хаагчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой 4 төрлийн баталгааг давхардсан тоогоор 300 гаруй алба хаагчаас гаргуулан авч, хэрэгжилтийг хангуулж ажилласан нь алба хаагчдыг сахилга, хариуцлага дээшлэх нэг хүчин зүйл боллоо.

8. Тайлангийн хугацаанд 10 алба хаагчид /офицер 4, ахлагч 6/ холбогдуулан 9 албаны шалгалтыг холбогдох журам, дүрмийн дагуу явуулсан бөгөөд албаны шалгалтаар зөрчлийн шинж байдал, хор уршиг, үр дагавар, анх буюу давтан үйлдсэн байдал, шалтгаан нөхцөл, гэм бууруугийн хэлбэр, зөрчил гаргагчийн хувийн байдал, /ар гэр ахуй амьдралын байдал/, хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал, ажлын үр дүн, удирдлагаас мэргэжил, арга зүйгээр хангасан байдал зэргийг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоож, дүнг Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн.

Дотоод хяналт шалгалтаар ирүүлсэн 2, гадны хяналтаар илрүүлсэн 7 гомдол мэдээлэлд албаны шалгалт явуулсан бөгөөд хэлбэрээр нь авч үзэвэл 4 буюу 44.4 хувийг хууль ёс, хүний эрх чөлөөг зөрчсөн, 1 буюу 11.1 хувийг бусдыг чирэгдүүлж танил тал харсан, 2 буюу 22.2 хувийг цагдаагийн алба хаагчийн харилцааны соёл, ёс зүй зөрчсөн, 2 буюу 22.2 хувийг архидан согтуурсан гэх зөрчлүүд тус тус эзэлсэн бөгөөд албаны шалгалт явуулахад бүх алба хаагчдын сахилга, ёс зүйн зөрчил гаргасан үйлдэл нь тогтоогдоогүй.

1.11. Санхүүгийн үйл ажиллагааны талаар.

1. Цагдаагийн газрын 2020 оны нийт төсөв 2.550.186.800 төгрөг бөгөөд энэ оны эхний 2 сарын байдлаар төсвийн гүйцэтгэл 423.511.211 төгрөг буюу 16.6 хувьтай ба санхүүгийн үйл ажиллагаа болон төсвийн зарцуулалтанд ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй бөгөөд Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаанд мөрдлөгө болгон ажилласан.

2. Монгол Улсын “Төсвийн тухай хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, Санхүү эдийн засгийн сайдын 2002 оны “Байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягт, түүнийг хөтлөх аргачлал”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журам”, 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”, ЦЕГ-ын даргын тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, Цагдаагийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажилласан.

Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт болон журнал, ерөнхий дэвтэрийг бүрэн хөтөлж, бараа материалын тайлан, үндсэн хөрөнгийн хөдөлгөөний бүртгэл, бусад тайланг сар, улирал бүр гаргаж, цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар сар бүр хэлэлцүүлэн, үр дүнг тооцон, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр засуулан, хөрөнгийн зарцуулалтын тайланг хугацаанд нь үнэн зөв гаргаж, холбогдох газарт хүргүүлсэн.

3. Шийтгэлийн хуудас маягт 1, 2 хуудасны тооцоог төвийн алба хаагч нар ажлын 3 хоногт, хэсгийн төлөөлөгч, цагдаа нар 14 хоногт багтааж санхүүтэй тооцоо хийж, үнэт цаасны тайланг сар бүр нярваар гаргуулан Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулан үр дүнг тооцож, санхүүгийн зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлэн.

Цагдаагийн ерөнхий газраас ирсэн бараа материал болон систем хооронд тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ажилласан.

4. Тайлангийн хугацаанд цагдаагийн газрын албаны автомашинуудын бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах зорилгоор цагдаагийн газрын төсвөөс 26 нэр

төрлийн 2.905.000 төгрөгний үнэ бүхий сэлбэг хэрэгсэл худалдан авч аюулгүй байдал, техникийн бүрэн бүтэн байдлаа хангуулсан бөгөөд Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хэлэлцэх асуудлын төлөвлөлтийн дагуу сар бүр шатах тослох материалын зарцуулалтын талаар танилцуулан хяналт тавьж ажилласан бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 16.000.000 төгрөгний шатахуун зарцуулсан.

1.12. Тайлангийн хугацаанд зохион байгуулсан, шинэлэг ажил, арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар.

1. Цагдаагийн газрын тасаг бүрээс нэг шинэ бүтээл-оноовчтой санал, тэргүүн туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, дэлгэрүүлэх талаар тодорхой хэрэгжих боломжтой санал, туршлыг нэвтрүүлэх талаар бэлтгэл ажлыг хангасан бөгөөд өнөөдрийн байдлаар хоёр шинэлэг ажил, санаачлагыг нэвтрүүлээд байна.

Тухайлбал:

Алба хаагчдын галт зэвсэг эзэмших, хэрэглэх ур чадварыг дээшлүүлэх зорилгоор орчин үеийн “СКАТ” буудалгын төхөөрөмжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.

2. Алба хаагчдын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бэлэн бус торгуулийн төхөөмжинд тусгай апплейкейшн суулгах замаар эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын байршлыг тогтоох, аюулгүй байдлыг хангах, дуудлага мэдээллийн дагуу хэрэг, зөрчлийн газарт түргэн шуурхай очих нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

3. Цагдаагийн газрын Шуурхай удирдлагын 102 утсанд иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн дуудлага бүрийг хадгалах, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, шийдвэрлэлтэнд тавих хяналтыг дээшлүүлэх зорилгоор 102 утасны хоёр талын яриаг бичиж хадгалдаг “USB CALL RECORDER” төхөөрөмжийг суурилуулж үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна.

4. Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд тусгай цонх үүсгэх замаар нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нараас гаргаж байгаа тушаал шийдвэрүүдийг нэгтгэж, Цагдаагийн ерөнхий газраас хянаж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаснаар тушаал шийдвэрт холбогдох хуулийн зүйл, заалтыг буруу хэрэглэх, утга найруулга, агуулгын хувьд алдаатай бичих, орхигдуулах, тушаал шийдвэр илт хууль бус болох, шийдвэр хүчингүйд тооцогдох зэрэг эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөл боломж бүрдэх зэрэг санал санаачлага гаргасан.

5. Алба хаагчдыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх зорилгоор цахим хуудас /фейсбүүк групп/ нээж, эрүүл мэндийн талаарх мэдээ мэдээлэл, зөвлөмж, санамж, шторк, видео зэргийг түгээж байгаа болно.

1.13. Бусад

1. “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь хэсэг, 15.2 дахь заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/133 тушаалаар баталсан “Иргэний зөвлөлийн дүрэм”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь хэсэг, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Цагдаагийн байгууллага, алба хаагчаас тайлан тавих /код 129/ журам”-ыг тус тус үндэслэн Цагдаагийн газрын 2019 оны үйл ажиллагааны тайлангийн хурлыг аймгийн 13 сум, 1 тосгоны оршин суугчдад тайлагнах ажлыг 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдөр баталсан удирдамжийн дагуу өргөн хүрээнд зохион байгууллаа.

Цагдаагийн газрын 2019 оны үйл ажиллагааны тайланг Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 28 дугаар хуралдаанаар хэлэлцэж, аймгийн Засаг даргад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 27/167, ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлд 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 27/52 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Аймгийн 13 сум, 1 тосгоныг 5 чиглэлд хувааж, тайлангийн хурлыг зохион байгуулах үйл ажиллагааг Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн гишүүдэд хариуцуулан томилон ажиллуулсан бөгөөд сумын удирдлагууд, иргэдтэй уулзах, санал хүсэлтийг сонсох, хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын үйл ажиллагаатай танилцан зааварчлах, ахмад ажилтнуудын ахуй амьдралтай танилцах зэрэг ажил, арга хэмжээг хэрэгжүүлэв.

Цагдаагийн газрын 2019 оны үйл ажиллагааны тайланг видео хэлбэрээр /16 минут/ бэлтгэж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон Цагдаагийн газрын албаны ёсны цахим хуудас /bayan-ulgii.police.gov.mn/, фейсбүүк орчинд сурталчлав.

Тайлангийн хурлын үеэр санал, хүсэлтийн хайрцаг ажиллуулж, Цагдаагийн газрын “Цагаан шонхор” хамтлаг урлагийн тоглолт сонирхуулсан бөгөөд 5 иргэн санал, 12 иргэн хүсэлт гаргаж, 11 иргэн цагдаагийн газрын үйл ажиллагаанд талархал илэрхийлсэн.

2. Алба хаагчдын сэтгэл санааны байдлыг илрүүлэх сэтгэл зүйн 3 багц асуулга, ажлаас халшрах хам шинжийг тодорхойлох судалгаа, оношилгоонд 70 алба хаагчийг хамруулж үр дүнгээр 2 хувь нь сэтгэл гутралтай, 16 хувь нь нойрны хямралын илрэлтэй буюу хямралтай, 36 хувь нь ажлаас халшрах мэдэгдэхүйц өөрчлөлттэй, 20 хувь нь ажлаас халшрах хам шинжийн түвшин өндөр буюу ажлаас халшрах өөрчлөлттэй, 28 хувь нь стрессийг бууруулах нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах зайлшгүй шаардлагатай зэрэг үзүүлэлттэй гарсан ба гарсан үр дүнг нийт алба хаагч нарт танилцуулж, давхардсан тоогоор нийт 17 алба хаагчид ганцаарчлан уулзаж, сэтгэл зүйн дэмжлэг туслалцаа үзүүлсэн бол алба хаагч нарт сэтгэл зүйн тусламж үзүүлэх зорилгоор “Бид зөвийг түгээнэ”, “Сэтгэл зүйн дархлаагаа сайжруулья” цахим хуудсыг нээн цагдаагийн газрын нийт алба хаагчдыг нэгтгэж, тэднийг төлөвшүүлэх, сэтгэл зүйн тусламж үзүүлэх, эерэг зөв хандлага, дадал зуршилтай болгоход чиглэгдсэн нийтлэл, мэдээ мэдээлэл, уриалга, богино хэмжээний видео бичлэг, онч, мэргэн үгс зэргийг өдөр тутам байршуулж алба хаагчдад сурталчилж ажилласан.

- Мөн алба хаагчдыг сэтгэл зүйн эрүүл мэндийн мэдээ мэдээллээр хангах, өөрсдөө стрессээс гарах аргад суралцах, стрессээс гаргах чадварын талаарх нийт 5 удаа дүрст болон цахим зөвлөмж боловсруулж танилцуулан түгээж ажилласан.

- Алба хаагчдад сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, стресс, сэтгэлийн хямралаас хамгаалах зорилгоор нийт 4 төрлийн сэтгэл зүйн судалгаа, оношилгоонд давхардсан тоогоор 85 алба хаагчийг хамруулж, дүгнэлт гаргаж, дүнг цагдаагийн газрын удирдлага болон алба хаагч нарт тухай бүрт нь танилцуулж, судалгааны дүнгээр 20 алба хаагчид 1-2 удаагийн давтамжтайгаар ганцаарчилан уулзалж, мөн давхардсан тоогоор 3 алба хаагчид 5 удаагийн сэтгэл зүйн холбогдох үйлчилгээ үзүүлэв.

- Алба хаагчдын сэтгэл санааны байдал, ажлаас халшрах хам шинжийн түвшинг тодорхойлох судалгааны дүнгээр ажлын стресстэй гэх 15, стресс туйлдах дөхсөн 2, нойрны хямралтай 4, нойрны хямралын илрэл бүхий 6, ажлаас халшрах хам шинжийн түвшин өндөр гарсан 14, давхардсан тоогоор нийт 41 алба хаагч тус бүртэй сэтгэл зүйчийн зүгээс ганцаарчлан уулзаж, сэтгэл зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэн шалтгаан нөхцөлийг арилгуулав.

- Алба хаагчдын гүйцэтгэж буй чиг үүрэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сэтгэл зүйн бэлтгэлжилт олгох зорилгоор “Өөртөө сэтгэл зүйн анхан шатны тусламж үзүүлэх”, “Хүчирхэг сэтгэл зүйтэй хүмүүсээс суралцах 10 зүйл” сэдвээр 1 цаг, “COVID-19-ийн дэлгэлтийн үеийн стрессийг даван туулах” ДЭМБ-аас гаргасан зөвлөмжөөр 1 цагийн мэдээлэл, нийт 2 цагийн сургалт, мэдээлэл зохион байгуулсан бөгөөд нийт 85 алба хаагч хамрагдсан.

3. Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны А/08 дугаар тушаалаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2020 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах зорилгоор

2 бүлэг, 21 заалт бүхий цагдаагийн газрын соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөг 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр баталж, өнөөдрийн байдлаар хэрэгжилтийг 29.5 хувьтай ханган ажиллаж байгаа бөгөөд хэрэгжилтийн шатанд болон тайлант оны эцэст хэрэгжилт 95 хувьтай хангагдах боломжтой гэж үзэж байна.

- Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр зохион байгуулсан 46 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор хамрагдсан 5786 алба хаагч, соёл, хүмүүжлийн чиглэлээр зохион байгуулсан 9 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 1181 хамрагдсан алба хаагч, нийт зохион байгуулсан 55 удаагийн ажил, арга хэмжээнд хамрагдсан 6967 алба хаагчийн мэдээллийг “Сургалтын мэдээллийн нэгдсэн бүртгэлийн сан /E surgalt/”-ийн соён гэгээрүүлэх ажлын бүртгэлийн цэсэнд бүрэн шивж оруулсан болно. Тухайлбал:

- Эмэгтэйчүүдийн талаарх төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх, алба хаагчдын соёл, гоо зүйн хүмүүжил, мэдлэгийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий эмэгтэйчүүдийн зөвлөлийг Цагдаагийн газрын даргын 2020 оны А/09, ахлагч бүрэлдэхүүний бүтээлч сэтгэлгээ, соёлыг төлөвшүүлэх, шинэлэг арга барил, шинэ санаа дэвшүүлэх, алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, сахилга, ёс зүйг дээшлүүлэх, бусдад үлгэрлэн дууриалал, манлайлал үзүүлж ажиллах ахлагч бүрэлдэхүүний зөвлөлийг Цагдаагийн газрын даргын 2020 оны А/10 дугаар тушаалаар тус тус баталж, тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулан үр дүнг тооцон ажилласан.

- Цагдаагийн газрын соён гэгээрүүлэх төлөвлөгөөний дагуу алба хаагчдын дунд соён гэгээрүүлэх ажлыг шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулах, алба хаагчдын бие биедээ хүндэтгэлтэй хандах нөхцөлийг бүрдүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, стрессийн нөлөөллийг бууруулах зорилгоор 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдөр алба хаагчдын дунд “Инээмсэглэцгээе” өдөрлөгийг удирдамжийн дагуу зохион байгууллаа.

Алба хаагчдад “Амжилтыг өнөөдөр өөрөөсөө” сурталчилгааны материалыг тараасан бөгөөд үүнд гэр бүл, хайр, мөрөөдөл, талархал, уучлал, үнсэлт, тэврэлт, инээмсэглэл, дасгал хөдөлгөөн зэрэг сайхан зүйлүүдийн ач холбогдол энэ бүхэн үнэгүй байдаг талаар мэдээлэл өгч сурталчлав.

Цагдаагийн газрын алба хаагчдын 2011-2019 оны хооронд авхуулж байсан зургуудаас хөгжилтэй 80 зургийг сонгон авч “Та битгий уурлаарай” зургийн цуглуулгыг алба хаагчдад танилцуулан инээмсэглэл бэлэглэв.

Алба хаагчид бүтэн өдөр нэг нэгэндээ ээлтэй инээмсэглэн харьцаж, уур бухимдал үүгэж байгаа асуудал түр зуурын асуудал гэдгийг ойлгуулан сэтгэл зүйн таатай нөхцөл бүрдүүлсэн.

- Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний 2.8 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллагаас төрөн гарсан алдартнууд, онцгой гавьяа байгуулсан, албан үүргээ гүйцэтгэж яваад амь эрсэдсэн алба хаагчдыг алдаршуулах, сурталчлах ажлыг сард нэгээс доошгүй удаа хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран зохион байгуулах” гэж заасныг дагуу Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн даргаар 9 жил тасралтгүй ажилласан цагдаагийн бэлтгэл хурандаа Тумысханы Костёрыг алдаршуулах, сурталчлах зорилгоор орон нутгийн “Саян” телевизтэй хамтран 28 минут, 07 секундын нэвтрүүлгийг бүтээж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд сурталчилснаар иргэд, олон нийтийн дунд цагдаагийн албаны нэр хүнд өсөх, эерэг ойлголт бий болох, алба хаагчдын албаараа бахархах сэтгэл омогшил төрөх зэрэг олон талын оч холбогдолтой ажил боллоо.

- Цагдаагийн байгууллагын сүр хүч, цог хийморийн илэрхийлэл болсон “Цагаан шонхор” бэлгэ тэмдэг болон алба хаагчийн ёс зүй, сахилга, албаны нууцыг чанд сахин, чин шударгаар ажиллахаа баталсан “Цагдаагийн тангараг”-ийг Цагдаагийн газрын иргэдийг хүлээж авах танхимд байрлуулсан алдарын буланд байршуулж,

тэдгээрийн утга учир, тайлбарыг Цагдаагийн албаны тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 73 дугаар тогтоолоор 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдөр нийт 90 алба хаагчдад 30 минутын сургалтыг зохион байгуулж, алба хаагч нараар судлуулсан.

- Албан үүргээ гүйцэтгэх явцдаа бусдын амь насыг аврах гэж яваад цэл залуу, халуухан насандаа алтан амиа алдсан Эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Ишгэний Эрдэнэшагайг алдаршуулах, сурталчлах зорилгоор орон нутгийн “Заман” сонины 2020 оны 04 дүгээр сарын 06 дугаар хэвлэлтэнд “Эр зоригийн тангарагтай эрэлхэг хөвгүүн” сэдэвт мэдээлэл нийтлүүлэхээр холбогдох танилцуулгыг хүргүүлэн бэлтгэл ажлыг хангасан.

4. Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2018 оны А/120 дугаар тушаалаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах ерөнхий 12 зорилтыг хэрэгжүүлэх 35 заалт бүхий ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/28 дугаар тушаалаар 8 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулж байна.

- Цагдаагийн газар үүсч байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг тохиолдуулан Цагдаагийн газрын тасаг, хэсгийн дарга нарын манлайллыг нэмэгдүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, ажлын бүтээмж, бүтээлч сэтгэлгээг төлөвшүүлэх зорилгоор Цагдаагийн газрын тасаг, хэсгийн дарга нарын дунд 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Дартсны тэмцээнийг Цагдаагийн газарт зохион байгууллаа.

Тэмцээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг Захиргааны удирдлагын тасаг хариуцан зохион байгуулсан бөгөөд цаашид алба хаагчдын дунд Дартсны тэмцээнийг бүрэн хөгжүүлэх боломжтой гэж үзлээ.

Дартс нь хүний харааг сайжруулах, оюун ухаан болон хүний баруун тархийг хөгжүүлэх, зөв шийдэл гаргахад чухал ач холбогдолтой юм байна.

- Гэр бүлээ хайрлах, хүндлэх, гэр бүлийн үнэ цэнэ, гэр бүлдээ хандах хандлагыг дээшлүүлэх, эерэг харилцааг түгээн дэлгэрүүлэх зорилгоор алба хаагч болон тэдний гэр бүлийн гишүүдийн дунд “Ханьдаа илгээх захидал” арга хэмжээг зохион байгуулав.

Уг арга хэмжээнд оролцсон алба хаагчид хань ижилдээ захидал бичиж баярласан талархсан чин сэтгэлээ илэрхийлж, гарын бэлэг гардуулан хүндэтгэл үзүүллээ.

- Цагдаагийн газрын алба хаагчид, ажилтан тэдний гэр бүлийн гишүүдийн эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх, хамт олны дунд эерэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор “Аав, Ээж, Би” хөгжөөнт буухиа тэмцээнийг Эрүүгийн цагдаагийн тасгаас зохион явуулав.

Тэмцээнд тус цагдаагийн газрын алба хаагч, ажилчид тэдний гэр бүлийн гишүүдээс бүрдсэн 8 багийн 24 алба хаагч, гэр бүлийн гишүүд авхаалж самбаа, хурд хүчээ дайчлан оролцсоноос I-р байранд Захиргаа удирдлагын тасгийн баг, II-р байранд Мөрдөн байцаах тасгийн баг, III-р байранд Эрүүгийн цагдаагийн тасгийн баг тус тус шалгарч, эхний III байранд шалгарсан баг, тамирчдыг цагдаагийн газрын “Өргөмжлөл”, үнэ бүхий зүйлээр шагнаж, тэмцээнд оролцсон хүүхдүүдэд гарын бэлэг гардуулсан.

- Алба хаагчдын алжаал, стрессийг тайлах, хамт олныг хөгжөөх, эерэг уур амьсгал бүрдүүлэх, алба хаагчдын жүжиглэх авьяас чадварыг хөгжүүлэх, идэвх, санаачлагыг нэмэгдүүлэх, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор тасаг, хэсгүүдийн дунд “Эрчүүд эмэгтэйчүүдийн дүр, эмэгтэйчүүд эрчүүдийн дүрд” сэдэвт хөгжөөнт тэмцээн зохион байгуулсан нь алба хаагчдад инээд, баяр баясгалан бэлэглэсэн ажил байв.

- Монгол улсын Зууны манлай уулчин, уулын спортын Олон Улсын хэмжээний мастер, бэлтгэл дэд хурандаа Н.Жуков алба хаагчдад “Хувь хүний хариуцлага” сэдвээр яриа таниулга хийлээ. Тэрээр дэлхийн дээвэр Еврестийн оргилд авиралт хийсэн ба Монгол Улсын дархан хилийн манаанд үүрэг гүйцэтгэх хугацаанд 48 хил зөрчигчийг барьж үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн байна.

Мөн өөрийн туулж өнгөрүүлсэн амьдралын тухай сонирхолтой яриа өрнүүлж, ялангуяа ур чадвар, туршлагад суурилсан үнэтэй сургамжаа ярьж, албаныхаа нэр төрийг өндөрт өргөж, залуу насандаа ихийг хийж бүтээж, хамгийн гол нь цагаан сэтгэлтэй, хүний мөс чанарыг эрхэмлэж явахыг алба хаагчдад зөвлөсөн зэрэг үр дүнтэй уулзалт болсон.

Хоёр: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

2.1. Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр:

1. Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар гэмт хэрэг, зөрчлийн талаарх 608 гомдол, мэдээлэл хүлээн авч бүртгэн шалгасан ба урьд оны үлдэгдэл 19 гомдол мэдээлэл нэмэгдээд нийт 627 гомдол мэдээллийг шийдвэрлэсэн бөгөөд өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 189 гомдол мэдээлэл буюу 23.1 хувиар буурсан байна.

Нийт 627 гомдол мэдээллээс гэмт хэргийн талаарх 164, зөрчлийн талаарх 463 гомдол мэдээлэл эзэлж байгаа бөгөөд одоо үлдэгдэл 15 гомдол, мэдээлэл шалгагдаж байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 160-г шийдвэрлэсэн бөгөөд 40 хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналаар прокурорт хүргүүлж, 120 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, харъяаллын дагуу шилжүүлсэн гомдол мэдээлэл бүртгэгдээгүй.

Гэмт хэргийн шинжтэй 164 гомдол мэдээллийн 160 буюу 97.5 хувийг 5-аас 14 хоногт шийдвэрлэж шалгуур үзүүлэлтийг ханган биелүүлсэн болно.

Гэмт хэргийн илрүүлэлт 61.6 хувьтай байгаа бөгөөд өнгөрсөн жилтэй харьцуулахад 39.1 хувиар өссөн ба бусад цагдаагийн байгууллагатай харьцуулахад өндөр үзүүлэлттэй байна.

Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг нөхцөл байдалтай уялдуулан үр дүнтэй зохион байгуулж ажилласнаар зам тээврийн осол, хэргийн тоо 3 нэгжээр буюу 50 хувиар, гэмтсэн хүний тоо 2 нэгжээр буюу 40 хувиар, зам тээврийн ослын улмаас учирсан хохирол 33.500.000 төгрөгөөр тус тус буурсан бол нас барсан хүн бүртгэгдээгүй байна.

Тайлангийн хугацаанд 115 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүнийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 13 нэгжээр буюу 10.2 хувиар буурсан байна.

- Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр:

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2020 онд хэрэгжүүлэх 23 заалт бүхий төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулан ажилласан. Үүнд:

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хяналт шалгалт-1”, “Шөнийн хяналт” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг Мэргэжлийн хяналтын газар, Мал эмнэлгийн газартай хамтран зохион байгуулж, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн зарж борлуулдаг цэг, зах, худалдааны төв, үйлдвэр, цех, мал нядалгааны газрын үйл ажиллагаанд 2 удаа үзлэг шалгалт хийж, нөөцлөгдсөн махны хэмжээ болон нийлүүлсэн махны хэмжээг бүртгэж мал, малын гаралтай түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээг шалган зөрчил дутагдлыг арилгуулсан.

Хилийн 0165, 0285 дугаар ангиудтай 2020 онд харилцан хамтран ажиллах талаар төлөвлөгөө гарган батлуулан хамтран ажиллаж байна.

Аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг “Тирлик”, “Ах дамы” “Малын зах”-уудад мал, мах худалдан борлуулдаг иргэдийн үйл ажиллагаанд 4 удаа хяналт шалгалт хийж, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар болон малын гарал үүслийн цахим бүртгэлийн чиглэлээр яриа таниулга хийж, “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлье” нэртэй 200 /хоёр зуун/ ширхэг сэрэмжлүүлэг хуудсыг тараасан.

Малын гарал үүслийн гэрчилгээний цахим системийн талаар цагдаа зохицуулагч, эргүүлийн цагдаа зэрэг нийт 14 алба хаагч нарт нэг цагийн сургалт зохион байгуулсан.

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн “9 мэдээ” радиогоор 2 удаа, орон нутгийн “Саян”, “Дербес” телевизээр тус бүр 3 удаа сэрэмжлүүлэг, нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэж, иргэд, олон нийтэд хүргэж, малчдад нийт 4 төрлийн 800 ширхэг санамж, сэрэмжлүүлэг бэлтгэж тараасан.

2020 оны эхний 3 сарын байдлаар малын хулгайн 16 хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүнийг өнгөрсөн жилтэй харьцуулахад 12 хэргээр буюу 75.0 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь илрүүлэлт өссөнтэй холбоотой.

Үйлдэгдсэн мал хулгайлах гэмт хэргийг өнгөөр нь авч үзвэл хөнгөн гэмт хэрэг 14, хүнд гэмт хэрэг 2 бүртгэгдсэн байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй 16 хэргээс 9 хэргийн эзэн холбогдогчийг олж тогтоон, илрүүлэлтийг 60 хувьд хүргэсэн.

Мал хулгайлах гэмт хэрэгт холбогдон шалгагдсан болон, энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн гэх нийт 138 сэжигтэй этгээдийн судалгааг гаргаж, хяналт тавьж ажилласан.

2.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/177 дугаар тушаалаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын бодлогын баримт бичиг, баримт бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тус тус баталсан бөгөөд тус цагдаагийн газраас бодлогын баримт бичиг, төлөвлөгөөг хэрэгжүүлэх салбар төлөвлөгөөг 2018 оны 07 дугаар сарын 17-ны өдөр цагдаагийн газрын даргаар батлуулж гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын 4 чиглэлийг тодорхойлж хэрэгжилтийг нь хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

2. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1 дүгээр хурлаар салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг ерөнхий чиглэл, тусгай чиглэл, соён гэгээрүүлэх чиглэл, авлига, ашиг сонирхлын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэл, сурталчилгааны чиглэл гэж 5 чиглэлээр баталж, төлөвлөгөөнд цагдаагийн байгууллага хариуцан хэрэгжүүлэхээр 18 ажил, арга хэмжээ тусгагдсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

3. Цагдаагийн газрын орон тооны бус судалгаа, дүн шинжилгээний баг тус аймагт 2019 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчилд 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр хийсэн судалгаа, дүн шинжилгээ болон санал, урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох тасаг, нэгжүүдийн зохион байгуулах ажлын төлөвлөгөөг цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2020 оны 5 дахь хуралдаанаар хэлэлцүүлж аймгийн хэмжээнд зонхилон үйлдэгддэг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээ, архидан согтуурахтай тэмцэх, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэсэгчилсэн арга хэмжээ тус тус зохион байгуулах саналуудыг танилцуулж холбогдох тасгийн дарга нарт тус тус үүрэг, чиглэл өгсөн.

4. Аймгийн Засаг даргад 2020 онд ажиллах олон нийтийн цагдаагийн тоог нэмэх, олон нийтийн цагдаа нарын урамшил, дүрэмт хувцасны зардлыг шийдвэрлүүлэх талаарх 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 27/257 дугаартай

танилцуулга 1, баяр, наадмын хамгаалалтын хайс хашаа нэмж хийлгүүлэх санхүүжилтийг шийдвэрлүүлэх талаарх танилцуулга 1, цагдаагийн явуулын пост хийлгэх танилцуулга 1, 2019 онд эрүүгийн хуульд заасны дагуу оногдуулсан торгох ял, Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйлүүдэд заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийн төсөвт төвлөрсөн дүнгээс 40-өөс доошгүй хувийг 2020 оны төсөвт урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар суулгах талаар 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 251 дугаар танилцуулга 1, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн төвийн хатуу хучилттай авто замын 3 уулзаварт гэрлэн дохио суурилуулах талаар 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 27/247 дугаартай танилцуулга 1, мөн зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Өлгий сумын төвд шинээр 268 ширхэг босоо, 46 газарт явган хүний гарцын хэвтээ тэмдэглэл хийлгүүлэх талаар 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 27/222 дугаартай танилцуулга 1, аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга буюу ИТХ-ын даргад 2019 онд эрүүгийн хуульд заасны дагуу оногдуулсан торгох ял, Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйлүүдэд заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийн төсөвт төвлөрсөн дүнгээс 40-өөс доошгүй хувийг 2020 оны төсөвт урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар тусгах талаар 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 252 дугаар танилцуулга 1, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн төвийн хатуу хучилттай авто замын 3 уулзаварт гэрлэн дохио суурилуулах талаар 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 27/249 дугаартай танилцуулга 1, мөн зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Өлгий сумын төвд шинээр 268 ширхэг босоо, 46 газарт явган хүний гарцын хэвтээ тэмдэглэл хийлгүүлэх талаар 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 27/221 дугаартай танилцуулга 1, Өлгий сумын Засаг даргад хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд ашиглах техник хэрэгсэл шийдвэрлүүлэх 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 27/246 дугаартай танилцуулга 1, Өлгий сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга буюу ИТХ-ын даргад хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд ашиглах техник хэрэгсэл шийдвэрлүүлэх 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 27/245 дугаартай танилцуулга 1, нийт 11 санал бүхий 11 танилцуулгыг хүргүүлснээс 55 хувийг шийдвэрлэсэн.

5. Шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр орон нутгийн төсөвт нийт 127.091.965 төгрөгийн торгуулийн мөнгийг тушаасан боловч тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний 50.836.786 төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардалд тусгаж өгөөгүй.

6. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2020 оны 1 дүгээр улиралд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд санхүүжилт олгоогүй, Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагын тус аймаг дахь салбараас “Архидан согтуурахтай тэмцэх боловсрол олгох” сэдэвт сургалтыг 2020 оны 01 дүгээр сард “Монгол өрх” сэтгэл зүйн хүрээлэнтэй хамтран зохион байгуулахад 2.500.000 төгрөг, НҮБ-ийн Хүн амын сангаас Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах байранд шаардлагатай эд хогшил худалдан авахад 20.000.000 төгрөг зэрэг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд нийт 22.500.000 төгрөг шийдвэрлэж өгсөн.

7. Цагдаагийн газраас аймгийн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд уялдуулан нийт 9 удаа хэсэгчилсэн арга хэмжээ, 9 удаагийн нэгдсэн үзлэг шалгалт, 49 удаа сургалт, мэдээлэл, сурталчилгаа, 1 удаа уулзалт, хэлэлцүүлэг, ярилцлага, 2

удаа өдөрлөг, 1 удаа уралдаан, тэмцээн зэргийг орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотой зохион байгуулсан бөгөөд нийт 4752 хүн хамрагдав.

8. *Ухуулга, яриа, сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэд, байгууллага:*

Арга хэмжээнүүдэд 2401 төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, 646 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, 250 малчин, 330 оюутан, 453 сурагч, ажилгүй 672, нийт 4752 хүн хамрагдсан байна.

9. *Бичсэн мэдэгдэл, шаардлага, авсан хариу:*

Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн, үйлдэгдэж болзошгүй шалтгаан нөхцөлийг арилгуулахаар 36 мэдэгдэл, 332 шаардлага хүргүүлж биелэлтийг 100 хувь хангасан бөгөөд 124 мэдэгдэл, шаардлагын биелэлтийг газар дээр нь шалгав. Хугацаандаа хариу ирүүлээгүй 2 албан тушаалтныг Зөрчлийн тухай хуулийн 5.9 дүгээр зүйлд зааснаар тус бүр 100.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан.

10. Орон нутгийн “Саян”, “Дербес” телевизээр гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ түүний үр дүнгийн талаар: телевизээр 28 удаагийн буюу 155 минутын мэдээ, мэдээллийг 54 удаагийн давталттай, радиогоор 31 удаагийн буюу 140 минутын мэдээ, мэдээллийг 62 удаагийн давталттай, “Баян-Өлгий Цагдаагийн газар” фейсбүүк, Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар фейсбүүк пэйж хуудас болон www.bayan-ulgii.police.gov.mn цахим хуудсанд 102 удаагийн мэдээ, мэдээлэл байршуулж, нэвтрүүлэг, ярилцлага бэлтгэн хүргэсэн.

11. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 36 төрлийн 6893 ширхэг гарын авлага, зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг иргэд, олон нийтэд тарааж ажиллав.

12. Тус Цагдаагийн газраас төрийн 25, төрийн бус байгууллага 4, 42 аж ахуйн нэгжийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажилласан.

13. Улсын хэмжээнд бүх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулагдсан “Сар шинэ-2020”, Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулагдсан “Ятгах тусам нягтал”, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Архигүй орчин”, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хайр өвтгөдөггүй”, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хүүхэд хэрэглэгч” зэрэг 5 удаагийн нэгдсэн арга хэмжээ, аяныг тус тус төлөвлөгөөний дагуу зохион байгуулав.

14. Цагдаагийн газрын алба хаагчдыг аймгийн төв Өлгий суманд үйл ажиллагаа явуулдаг 76 аж ахуйн нэгж байгууллагыг цагдаагийн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 дугаар тушаалаар хариуцуулж 2020 оны эхний 3 сарын байдлаар давхардсан тоогоор 82 албан хаагч 76 аж ахуйн нэгж байгууллагад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тус бүр 1 удаа зохион байгуулснаар иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилж хуулиа сахин биелүүлэх сэтгэлгээ дээшилсэн болно.

2.5. Замын цагдаагийн албаны чиглэлээр

1. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоолоор баталсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги (2012-2020 он), Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 163 дугаар тогтоолоор баталсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр”, Цагдаагийн газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 22 ажил, арга хэмжээ, Замын цагдаагийн тасгийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 34 төрлийн ажил, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, биелэлт үр дүнг тооцов.

2. Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албанаас замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах зорилгоор “Сар шинэ”, “Согтуу-Хяналт, шалгалт”,

“Тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэг хэрэгсэл”, “Үзлэг-Оношлогоо”, “Тусгай дуут болон гэрлэн дохио”, “Замын тэмдэг, тэмдэглэл” зэрэг 6 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг тус тус зохион явуулж, үр дүнг тооцов.

3. Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнийг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр нэгдсэн хяналт, шалгалтанд 2 удаа татан оролцуулж, гудамж, замд давхардсан тоогоор Замын цагдаагийн тасгийн 820 алба хаагч 7500 цагийн үүрэг гүйцэтгэж, зөрчил үйлдсэн 2029 зөрчил илрүүлэн, 2016 жолоочийг 76.049.465 төгрөгөөр торгож хариуцлага тооцов.

Үүнээс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 80 зөрчил илрүүлэн, эрхийн үнэмлэхгүй согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 13 хүнийг шүүхийн шийдвэрээр 7-30 хоногийн хугацаатай баривчлуулан, 67 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаатай хасаж, 26.800.000 төгрөгөөр, эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 39 жолоочийг 7.800.000 төгрөгөөр тус тус торгож арга хэмжээ авч ажилласан.

Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх, хурд хэтрүүлэхгүй байх, бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцохгүй байх чиглэлээр замын хөдөлгөөнд оролцож явсан жолооч нарт 4000 ширхэг сэрэмжлүүлэг тарааж ажилласан.

Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг нөхцөл байдалтай уялдуулан үр дүнтэй зохион байгуулж ажилласнаар зам тээврийн осол, хэргийн тоо 3 нэгжээр буюу 50 хувиар, гэмтсэн хүний тоо 2 нэгжээр буюу 40 хувиар, зам тээврийн ослын улмаас учирсан хохирол 33.500.000 төгрөгөөр тус тус буурсан бол нас барсан хүн бүртгэгдээгүй байна.

Аймгийн төвийн жолооны сургуулиудад ABCDE ангилалд бүртгэгдсэн 158 иргэний материалыг хүлээн авч, шийдвэрлүүлсэн.

3. “Газрын-од”, “Цэнгэл транс” ХХК-ны Өлгий-Улаанбаатар чиглэлд хүн тээвэрлэдэг хот хоорондын нийтийн тээврийн 45 айро автобусыг давхардсан тоогоор 2 удаа, аймгийн төвийн “Тасмал хоршоо”, “Жанарту” зэрэг аж ахуйн нэгжүүдийн нийтийн тээврийн 70 микробус, хот дотор хувиараа таксины үйлчилгээ эрхэлдэг 60 жолоочийг давхардсан тоогоор 2 удаа шалгаж, тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг хангуулсан.

2.6. Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр:

1. Аймгийн төвд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн криминалоги судалгаа, цахим зураглал, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгийн судалгаанд үндэслэн Цагдаагийн газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/69 тоот тушаалаар эргүүлийн нэгдсэн байршилтийг тус тус шинэчлэн баталсан ба эргүүлийг гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг, хүн амын суурьшил, хөдөлгөөн ихтэй газруудад томилон ажиллуулж, тасгийн дарга, ахлах байцаагч нар хяналт тавин ажилласан.

Эргүүлийг өдөр болон оройн цагийн хуваариар, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэглэлд шилжин ажиллаж байгаа үед 24 цагийн хугацаанд тодорхой цагийн хуваариар томилон ажиллуулсан.

2. Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр 2020 оны 01 дүгээр улирлын байдлаар давхардсан тоогоор 2024 алба алба хаагч 16.192 цагийн хугацаанд эргүүлийн үүрэг гүйцэтгэж, эргүүлийн хяналтаар нийт 689 тооны зөрчил илрүүлэн 689 зөрчилд 12,810,000 төгрөгийн торгууль оногдуулж, 100 зөрчлийг шалгуулахаар эрх бүхий алба хаагчдад хүлээлгэн өгсөн байна.

Цагдаагийн байгууллагын нийт алба хаагчид хэв журмын хамгаалалт, эргүүл, харуул, жижүүрийн үүрэг гүйцэтгэхдээ илрүүлсэн зөрчилд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлд заасан үндэслэл тогтоогдвол Улсын ерөнхий прокурорын 2017 оны А/54 дүгээр тушаалаар баталсан “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хэлбэр”-ийн хялбаршуулсан журмаар зөрчил шалган

шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэл, Засгийн газрын 2017 оны 194 дүгээр тогтоолоор баталсан “Хялбаршуулсан журмаар шийдвэрлэх зөрчилд шийтгэл оногдуулах шийтгэлийн хуудас”-ыг үйлдүүлэн зөрчлийг газар дээр нь шийдвэрлүүлж хэвшсэн.

3. 2020 оны мөн үеийн байдлаар цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнийг 4 удаа, тасаг, албадыг хэсэгчилсэн байдлаар 5 удаа эргүүлд томилон ажиллуулж, аймгийн төвийн гудамж зам, гэр хорооллын гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй 123 цэгийг эргүүлийн хяналтад авч, нөхцөл байдлыг судлах, нийтийн хэв журам сахиулах ажлыг зохион байгуулан ажилласан.

Эргүүлийн үйл ажиллагааны хүрээнд давхардсан тоогоор 185 тооны төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн ажилчин, алба хаагчдад архины хор хөнөөл, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулиудаар сургалт зохион байгуулсан ба аймгийн төвд архи согтууруулах ундаа худалдах, үйлчлэх үйл ажиллагаа эрхэлдэг 97 иргэнд хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион явуулсан.

4. Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий алба хаагчид иргэд, байгууллагаас ирүүлсэн зөрчлийн шинжтэй 450 тооны гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэснээс 77 гомдол, мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж, 110 гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзан, 3 гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж, 249 гомдол, мэдээллийг хялбаршуулсан журмаар шалгаж шийдвэрлэсэн. Зөрчлийн хэрэгт 62 хүнийг захиргааны журмаар баривчилж, 397 хүнд 67,830.000 төгрөгний торгууль оногдуулж, 77 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нь хасаж шийдвэрлэсэн байна.

5. Шүүхээс хорих ялыг тэнсэн хянан харгалзсан, хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан, насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан нийт 12 ялтанд хяналт тавьж ажилласнаас хяналтын хугацаа дууссан 6 ялтны захиргааны хяналтыг зогсоож, одоо 6 ялтанд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд нийтийн хэв журам хамгаалах тасгийн даргын зүгээс хяналтын материалтай сар бүр биечлэн танилцаж, үүрэг, чиглэл өгч, хэрэгжилтийг нь хангуулан ажилласан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/260, А/242 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журам”-д заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа нэгжгүй сумдад ажиллаж байгаа тус Цагдаагийн газрын сумдын хэсгийн мөрдөгч нараас 2020 оны мөн үеийн байдлаар нийтэд тустай ажил хийлгэх ялтай 5, эрх хасах ялтай 8, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан 2 нийт 15 ялтанд хяналт тавьж, хяналтын мэдээг сар бүрийн 30-ны дотор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ирүүлэх ажлыг хэвшүүлсэн.

6. Шинэ коронавирус өвчнөөс урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай аймгийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/44, 2020 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/127 дугаартай захирамжаар аймгийн хэмжээнд нийтийг хамарсан арга хэмжээ, уралдаан тэмцээн, жагсаал, цуглаан, сургалт, үзвэр үйлчилгээ явуулах, согтууруулах ундаагаар үйлчлэх явдлыг 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хориглосон ба захирамжийн биелэлтэд цагдаагийн газраас хяналт тавьж, хэрэгжилтийг нь хангуулан ажилласан. Тус улирлын байдлаар тус аймагт урлаг, соёлын арга, хэмжээ, жагсаал цуглаан зохион байгуулагдаагүй.

Дэлхийн улс орнуудад дэгдээд байгаа коронавирусын халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар Монгол улсын Засгийн газар, улсын Онцгой комисс, ЦЕГ, аймгийн Засаг даргаас гаргасан нийт 25 удаагийн тогтоол, тушаал, шийдвэр, хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэн ажилласан.

Тус хугацаанд коронавирусын сэжигтэй 4 тохиолдлын улмаас нийт 419 хүнийг цагдаагийн хамгаалалтад тусгаарлалт, ажиглалтад, 59 хүнийг гэр ажиглалтад авч хяналт тавьж ажилласан.

2020 оны 01 дүгээр сарын 11-17, 02 дугаар сарын 25-28, 02 дугаар сарын 23-наас 26, 2020 оны 02 дугаар сарын 27-наас 03 дугаар сарын 03, 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 03 дугаар сарын 26-ны өдрүүдэд 40 хоногт нийт давхардсан тоогоор 746 алба хаагч аймаг, сумаас орж гарах хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох, ажиглалт, тусгаарлалтын байранд хамгаалалтын үүрэг гүйцэтгэн ажилласан.

7. Эрүүлжүүлэх, саатуулах байрны үйл ажиллагаанд ЦБҮАЖурам /код 629/, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/246 тоот тушаалаар батлагдсан “Баривчлах байрны дотоод журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайд, сангийн сайдын хамтарсан А/63, 70 дугаар тушаалаар батлагдсан “Баривчлагдсан этгээдийн баривчлах байранд байсан хугацааны шууд зардлын хэмжээг тооцох журам/ зэрэг журам, дүрмийг чанд мөрдөн ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээний ерөнхий шаардлага MNS 5527:2014 стандарт, хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ MNS 5080:2001 стандартын шаардлага хангаж байгаа эсэх талаар аймгийн прокурорын байгууллагаас 7 удаа, цагдаагийн газрын дарга удирдлагууд 10 удаа, тус цагдаагийн газрын ёс журмын эргүүл болон эрх бүхий алба тушаалтнууд 92 удаагийн хяналт шалгалт хийсэн ба энэ хугацаанд ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

2020 оны 01 дүгээр улирлын байдлаар тус цагдаагийн газрын эрүүлжүүлэх байранд 315, саатуулах байранд 20, захиргааны журмаар баривчлах шийтгэл эдлүүлэх байранд 62 хүнийг хүлээн авч, эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах шийтгэлийг эдлүүлсэн.

Мөн шүүхээс эрэн сурвалжлуулахаар даалгасан 6 хариуцагчийг олж тогтоож шилжүүлсэн.

8. Шүүхийн байрны хамгаалалтанд харуулын 4 цагдаа нар томилгооны дагуу 24 цагаар үүрэг гүйцэтгэсэн ба тус хугацаанд шүүхээр үйлчлүүлсэн 1341 иргэнийг биеийн байцаалтыг шалгаж зохих журмын дагуу шүүхийн ажилтнуудтай уулзуулан, шүүхийн байрны аюулгүй байдлыг хангаж ажиллав.

Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхэд 103, Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхэд 298, Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 33, зөрчлийн 63, цахим шүүх хурал 2 удаа, нийт 499 удаагийн шүүх хуралдаанд шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангаж, шүүн таслах ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлж, шүүх хуралдааны журам сахиулж ажилласан.

Хуяглан хүргэх ажиллагааны явцад 48 яллагдагчийг автомашинтай 35 удаа хуяглан хүргэж ажилласан.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, хуяглан хүргэх ажиллагаатай холбоотой ямар нэгэн зөрчилгүй дутагдал гаргаагүй болно.

Шүүхийн тамгын газартай хамтран ажиллах төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шүүхийн шүүгч нартай хамтарсан зөвлөгөөнийг 1 удаа зохион байгуулж, цаашид хэрэгжүүлэх ажил, аюулгүй байдлын талаар санал солилцсон.

Шүүхийн тамгын газарт санал хүргүүлэн тус шүүхийн байранд хийсэн өргөтгөлөөс яллагдагч, шүүгдэгчийг түр саатуулах, насанд хүрээгүй оролцогчийг насанд хүрсэн оролцогчоос тусгаарлан, харгалзах өрөө тасалгааг шийдвэрлүүлсэн.

2.7. Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны чиглэлээр:

1. Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар гэмт хэрэг, зөрчлийн талаарх 608 гомдол, мэдээлэл хүлээн авч бүртгэн шалгасан ба урьд оны үлдэгдэл 19 гомдол мэдээлэл нэмэгдээд нийт 627 гомдол мэдээллийг шийдвэрлэв.

Нийт 627 гомдол мэдээллээс гэмт хэргийн талаарх 164, зөрчлийн талаарх 463 гомдол мэдээлэл эзэлж байгаа бөгөөд одоо үлдэгдэл 15 гомдол, мэдээлэл шалгагдаж байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 160-г шийдвэрлэсэн бөгөөд 40 хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналаар прокурорт хүргүүлж, 120 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, харъяаллын дагуу шилжүүлсэн гомдол мэдээлэл бүртгэгдээгүй.

Гэмт хэргийн шинжтэй 164 гомдол мэдээллийн 160 буюу 97.5 хувийг 5-аас 14 хоногт шийдвэрлэж шалгуур үзүүлэлтийг ханган биелүүлсэн болно.

2. Нийт бүртгэгдсэн 115 гэмт хэргийн улмаас иргэд аж ахуйн нэгжид 183.3 сая төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад нийт учирсан хохирлын 114.4 сая төгрөг буюу 62,4 хувийг нөхөн төлүүлж, 41.6 сая төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилж ажилласан байна.

3. Гэмт хэргийн улмаас 4 хүн нас барж, 47 хүн хүнд, хөнгөн хэлбэрийн гэмтэл авч, нийт 105 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдаж үүнээс хүүхэд оролцсон гэмт хэрэг 5, эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 11, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 16, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 20, бүлэглэн үйлдэгдсэн гэмт хэрэг 16 тус тус бүртгэгдсэн.

4. Хариуцсан нэгжийн хэмжээнд мэдээллийн сантай холбоотой журмын хэрэгжилтийг хангах, мэдээллийн нэгдсэн сантай холбоотой гарч байгаа зөрчлийн шалтгааныг тогтоож, гарсан зөрчлийг арилгуулах, цаашид зөрчил гаргуулахгүй байх талаар алба хаагч нарт 12 цагийн сургалт зохион байгуулж, сургалтанд 92 алба хаагч хамрагдав.

5. Цагдаагийн газрын тасгийн дарга нарт Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны холбогдох журам, мэдээллийн сангийн ашиглалтыг сайжруулах талаар 3 удаа зааварчилга өгч хэрэгжилтийг хангуулсан. Тухайлбал:

Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд өдөр тутам шивэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл түүний шийдвэрлэлт, зөрчлийн хэргийн бүртгэл, шийдвэрлэлт, торгуулийн хуудас, хэрэг бүртгэлтийн болон эрүүгийн хэргийн маягт шивж оруулж буй алба хаагч нарын мэдээллийн санд гарч байгаа зөрчил дутагдал түүнд хийсэн үнэлэлт дүгнэлтийг үндэслэн Цагдаагийн газрын тасаг, хэсгийн дарга нарт 2020 оны 01 дугаар сарын 19-ны өдөр 9 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж, биелэлт үр дүнг тооцов.

6. Цагдаагийн газрын Мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн, зөрчлийн тоо бүртгэгч нарт үүрэг, ажлын чиглэл өгч мэдээллийн сантай өдөр бүр танилцаж, 7 хоног бүрийн “Даваа”, “Баасан” гарагт нийт бие бүрэлдэхүүнд мэдээлэл өгч, мэдээллийн сангийн ашиглалтыг Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар сар бүр хэлэлцэж, мэдээллийн сангийн зөрчлийг арилгуулан ажиллав.

7. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Монгол улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх /код-701/ журам”, “Зөрчлийн тоо бүртгэл хөтлөх /код-702/ журам”-ын талаар Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнд 4 цагийн сургалт зохион явуулав.

8. Мэдээллийн сангаас сар бүр боловсруулан гаргасан “Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ”, “Эрүүгийн хэргийн хөдөлгөөн шийдвэрлэлтийн мэдээ”, “Түдгэлзүүлсэн хэргийн мэдээ”-ний тайлангийн үзүүлэлтэнд сар бүр тулгалт хийж, сангийн зөрүүг арилгаж, аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын мэдээг дараа сарын 05-ны дотор хүснэгтээр гаргаж, аймгийн Засаг даргын тамгын газрын Статистикийн болон Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлж байна.

9. Мэдээллийн сангийн бүрдлийг хангах, хэвшүүлэх, ашиглах, мэдээллийн зөрүүтэй байдал үүсгэх зөрчил гаргуулахгүй тулд сум дахь хэсгийн төлөөлөгч нараас цаасан суурьтай мэдээ, тайлан авах үед сантай давхар тулгалт хийх ажлыг хэвшүүлсэн.

10. 2020 оны 01 дүгээр улиралд 2845 нийт зөрчил бүртгэгдэж зөрчилд холбоотой 302 хүн саатуулагдаж, 53 хүн шүүхээр баривчлагдаж, 2705 хүнд нийт 118.251.000 мянган төгрөгийн торгуулийн шийтгэл оногдуулж, 77 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасав.

11. Улсын бүртгэлийн хэлтсээс овог, нэр өөрчлөх, хүүхэд үрчлэх гэх зэргээр ирүүлсэн нийтдээ 350 хүн, хуулийн этгээдийн материалыг, ард иргэдээс ирүүлсэн 2095 материалыг тус тус хүлээн авч нэгдсэн сүлжээгээр МДШШУА-д хүргүүлэв.

Мөн хэрэг бүртгэгч, мөрдөгч, эрүүгийн мөрдөгч нарын өгсөн 140 хүн, хуулийн этгээдийн ял шалгах хуудсыг холбогдох газарт хүргүүлэв.

2.8 Дотоодын цэргийн тусгай салаа /гэрээт/-ны үйл ажиллагааны чиглэлээр:

1. Улсын онц чухал объектын хамгаалалтыг Дотоодын цэргийн штабын даргын 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн МН-2/60 дугаар албан тоотоор ирүүлсэн Дотоодын цэргийн командлагчийн 2019 оны МН/171 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоодын цэргийн алба-ажиллагааг 2020 оны эхний хагас жилд зохион байгуулах удирдамж” мөн Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч, Дотоодын цэргийн штабын дарга, Цагдаагийн газрын дарга нарын нарын өгсөн үүрэг, ажлын чиглэлийн дагуу хуулиар тогтоосон үүргээ бүрэн хэрэгжүүлж, алба-ажиллагааг хууль тогтоомж, дүрэм, стандарт, үйл ажиллагааны журмаар зохион байгуулж, үндсэн зорилтоо ханган ажиллаж байгаа ба улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагааг зохион байгуулахад нийт 14 төрлийн бүртгэл судалгааг хөтөлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаа.

Тусгай салаанаас УОЧО-ын харуул хамгаалалтад 3 офицер, 11 харуулчин ахлагч үүргээ хэвийн гүйцэтгэж байна.

2. Цагааннуурын худалдааны чөлөөт бүс нь байгуулагдсанаас хойш одоог хүртэл үндсэн ажлын чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй байгаа.

3. Тус салаа нь “Цагааннуур” тосгон дахь чөлөөт бүс УОЧО-ын харуул хамгаалалтыг хариуцаж, харуулын дарга нар 3 ээлж, харуулчин ахлагч нар 4 ээлжээр долоо хоногоор чөлөөт бүсийн худалдааны төвийн офиссын төв байр, зочид буудал, 10 склад агуулах, “VIP SHOP” дэлгүүр, харуулын 5 шалган нэвтрүүлэх байр, 16,000 метрийн тойрог бүхий төмөр торон хашааг хяналтанд авч харуулын үүргээ хэвийн гүйцэтгэв.

4. Тайлангийн хугацаанд улсын онц чухал объектын хамгаалалтад 3 харуулын дарга, 11 ахлагч нийт давхардсан тоогоор 2016 цагийн үүрэг гүйцэтгэж, объектод байнгын үнэмлэхээр 2 иргэн, гаднаас 13 иргэн, 7 тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу шалган нэвтрүүлж, 11187 удаагийн бусад хөдөлгөөнийг бүртгэж нийт 11209 удаагийн хөдөлгөөнд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулав.

5. Объектын хамгаалалтын талаарх нөхцөл байдлын мэдээг Цагдаагийн ерөнхий газрын шуурхай удирдлагын төвд өдөрт 2 удаа, Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албанд цаг тутам өгч, харуулчин ахлагч нар харуулын даргад нөхцөл байдлын мэдээг 30 минут тутамд тасралтгүй дамжуулан ажилласан.

6. Дотоодын цэргийн штабаас 2020 онд хяналтад авсан баримт бичгийн зүйл заалтын дагуу 2020 оны нэгдүгээр улирлын байдлаар нийт 10 удаагийн хөтөлбөр, төлөвлөөгөөний хэрэгжилтийг хангаж, ЦЕГ-ын дарга, дэд дарга бусад холбогдох дарга нараас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийн биелэлт, 22 удаагийн сарын тайлан мэдээ, 10 удаагийн судалгаа, хүсэлт, санал асуулга болон бусад 7 төрлийн баримт бичгийг тухай бүр гаргаж цагдаагийн газрын даргаар баталгаажуулж, цагдаагийн газрын албан тоотоор баталгаажуулан Дотоодын цэргийн ийн штабт хүргүүлсэн.

Гурав: Дүгнэлт

1. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2020 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ шалгуур үзүүлэлтийн түвшинд гүйцэтгэж ажилласан.

2. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт үр дүнг тооцох 96 төрлийн баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнасан.

3. Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар гэмт хэрэг, зөрчлийн талаарх 608 гомдол, мэдээлэл хүлээн авч бүртгэн шалгасан ба урьд оны үлдэгдэл 19 гомдол мэдээлэл нэмэгдээд нийт 627 гомдол мэдээллийг шийдвэрлэсэн бөгөөд өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 189 гомдол мэдээлэл буюу 23.1 хувиар буурсан байна.

Нийт 627 гомдол мэдээллээс гэмт хэргийн талаарх 164, зөрчлийн талаарх 463 гомдол мэдээлэл эзэлж байгаа бөгөөд одоо үлдэгдэл 15 гомдол, мэдээлэл шалгагдаж байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 160-г шийдвэрлэсэн бөгөөд 40 хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналаар прокурорт хүргүүлж, 120 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, харъяаллын дагуу шилжүүлсэн гомдол мэдээлэл бүртгэгдээгүй.

Гэмт хэргийн шинжтэй 164 гомдол мэдээллийн 160 буюу 97.5 хувийг 5-аас 14 хоногт шийдвэрлэж шалгуур үзүүлэлтийг ханган биелүүлсэн болно.

4. Гэмт хэргийн илрүүлэлт 61.6 хувьтай байгаа бөгөөд өнгөрсөн жилтэй харьцуулахад 39.1 хувиар өссөн ба бусад цагдаагийн байгууллагатай харьцуулахад өндөр үзүүлэлттэй байна.

Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг нөхцөл байдалтай уялдуулан үр дүнтэй зохион байгуулж ажилласнаар зам тээврийн осол, хэргийн тоо 3 нэгжээр буюу 50 хувиар, гэмтсэн хүний тоо 2 нэгжээр буюу 40 хувиар, зам тээврийн ослын улмаас учирсан хохирол 33.500.000 төгрөгөөр тус тус буурсан бол нас барсан хүн бүртгэгдээгүй байна.

5. Тайлангийн хугацаанд 115 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүнийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 13 нэгжээр буюу 10.2 хувиар буурсан байна.

Гамшгаас хамгаалах ажлын төлөвлөгөө, Онцгой нөхцөл байдлын үед Хил хамгаалах, Онцгой байдал, Зэвсэгт хүчний байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөөнд тодотгол хийж батлуулан, шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэн ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос гаргасан 6, ЦЕГ-ын даргын Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэглэлд шилжүүлэн ажиллуулах тухай 2020 оны А/52, А/64, А/90 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 10 удаагийн захирамж шийдвэрийн дагуу хөдөлгөөний хязгаарлалт, хорио цээрийн дэглэмийг зөрчил дутагдалгүй хэрэгжүүлэн ажилласан.

Тус аймгаас Ховд аймаг, Улаанбаатар хот руу явах, мөн сумдаас аймаг руу орох, гарах хөдөлгөөнийг хязгаарлах, хамгаалах, ажиглах байрны хамгаалалтын чиглэлээр 35 цэг байгуулан ажиллуулсан ба хяналтын цэгт давхардсан тоогоор цагдаагийн 702 алба хаагч үүрэг гүйцэтгэсэн бөгөөд алба хаагчдын ажиллах орчин, аюулгүй байдлыг бүрэн хангаж ажилласан.

6. Алба хаагчдын сахилга, ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласны үр дүнд цагдаагийн газрын алба хаагчдаас 2019 оны эхний 3 сарын байдлаар 5 алба хаагч сахилга, ёс зүйн зөрчил гаргасан бол энэ жилийн эхний 3 сарын байдлаар сахилга, ёс зүйн зөрчил гаргасан алба хаагч бүртгэгдээгүй болно.

Дөрөв: Санал

1. Алба хаагчдын үүрэг гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах ажил, арга хэмжээг үе шаттай зохион байгуулах.
2. Алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах.
3. Улсын Их Хурлын сонгуулийн хамгаалалтыг хууль, журмын дагуу зөрчил, дутагдалгүй зохион байгуулах.

ЦАГДААГИЙН ГАЗАР